

Хэрэглэгчдэд зориулсан эм хэрэглэх заавар

**Фурасол 100мг (Furasol 100mg)**

Гадуур хэрэглэх усмал бэлтгэхэд зориулсан нунтаг

Уусдаг Фурагин

**Бэлдмэлийг хэрэглэхийн өмнө уг эм хэрэглэх зааврыг анхааралтай уншина уу. Учир нь танд хэрэгтэй чухал мэдээлэл агуулна.**

Уг бэлдмэлийг эмчлэгч эмч болон эм зүйчийн зааврыг, эсвэл уг эм хэрэглэх зааврыг нарийн баримтлан хэрэглэнэ.

- Уг эм хэрэглэх зааврыг хадгалаарай. Учир нь түүнийг дахин унших шаардлага гарч болно.
- Хэрэв танд илүү мэдээлэл болон зөвлөгөө хэрэгтэй болвол эм зүйчээс асуугаарай.
- Хэрэв танд ямар нэгэн гаж нөлөө илэрвэл эмчлэгч эмч буюу эм зүйчдээ мэдэгдээрэй. Үүнд уг эм хэрэглэх зааварт тэмдэглэгдээгүй гаж нөлөө хамаарна. 4-р хэсгийг үз.
- Эмчилгээг эхэлснээс хойш 3-5 өдрийн дараа таны биеийн байдал сайжрахгүй буюу эсвэл дордвол эмчлэгч эмчдээ хандаж зөвлөгөө аваарай.

**Уг эм хэрэглэх зааварт:**

1. Фурасол гэж юу вэ? Түүнийг юунд хэрэглэдэг вэ?
2. Фурасол бэлдмэлийг хэрэглэхийн өмнө та юу анхаарах вэ?
3. Фурасол бэлдмэлийг яаж хэрэглэх вэ?
4. Илэрч болох гаж нөлөө
5. Фурасол бэлдмэлийг хэрхэн хадгалах вэ?
6. Савалтны агууламж болон бусад мэдээлэл

**1. Фурасол гэж юу вэ? Түүнийг юунд хэрэглэдэг вэ?**

Фурасол бэлдмэлийн үйлчлэгч бодис уусдаг фурагин нь нитрофураны уламжлалын бактерийн эсрэг бэлдмэл. Түүнийг амны хөндий ба хоолойн үрэвсэл, түлэгдэлт, халдвялгадсан шарх, идээт үрэвсэл зэргийн хэсэг газрын (гадуур) эмчилгээнд хэрэглэх усмал бэлтгэхэд хэрэглэнэ.

**2. Фурасол бэлдмэлийг хэрэглэхийн өмнө та юу анхаарах вэ?**

Дараах тохиолдолд бэлдмэлийг хэрэглэхийг цээрлэнэ.

- Фурагин болон нитрофураны уламжлалын бусад бэлдмэлд хэт мэдрэг хүмүүс
- Харшлын гаралтай арьсны үрэвсэл

Бэлдмэлийг 4 хүртэл насны хүүхдэд хоолой зайлх зорилгоор хэрэглэхгүй.

Учир нь энэ насны хүүхдэд хоолойгоо зайлж чаддаггүй.

**Анхааруулга ба болгоомжлол!**

Усмалыг хэрэглэснээр арьс шар өнгөтэй болно.

Хэрэв эмчилгээний үед согтууруулах ундааны зүйл хэрэглэвэл арьсны харшлын урвал илүү илэрдэг.

**Эмийн харилцан үйлчлэл:**

Бэлдмэл антибиотикин үйлдлийг хүчжүүлнэ.

**Жирэмсэн ба хөхүүл үеийн хэрэглээ:**

Хэрэглэхийг зөвлөхгүй. Ямар нэгэн эмийн бэлдмэл хэрэглэхээсээ өмнө эмч болон эм зүйчтэйгээ зөвлөнө.

**Жолоо барих болон машин механизмтай ажиллах чадварт бэлдмэлийн үзүүлэх нөлөө:**

Фурасол жолоо барих болон машин механизмтай ажиллах чадварт нөлөөлөхгүй.

**3. Фурасол бэлдмэлийг яаж хэрэглэх вэ?**

Хэсэг газрын эмчилгээнд хэрэглэх уусмалыг хэрэглэхээсээ өмнө бэлтгэнэ. Бэлтгэсэн уусмалыг хадгалахгүй. Уутан дахь агууламжийг аяга (200мл) буцалсан халуун усанд уусгах ба бүлээн уусмалаар хоногт 2-3 удаа хоолойгоо зайлж хэрэглэнэ.

Уутан дахь агууламжийг аяга (200мл) буцалсан халуун ус болон нэрмэл усанд уусгана. Уусмалыг халдвартлагдсан шарх, түлэгдэлт, идээт үрэвслийн үед хоногт 1-2 удаа хэрэглэнэ.

**4. Илэрч болох гаж нөлөө**

Бэлдмэлийг хэрэглэх үед бусад эмийн бэлдмэлийн нэгэн адилаар гаж нөлөө ажиглагдаж болно.

Уусмал нь зарим тохиолдолд арьсны харшлын урвал үүсгэж болно. Энэ үед эмчилгээг хойшилуулахгүйгээр шууд зогсоо ба эмчид хандаж зөвлөгөө авах хэрэгтэй.

**5. Фурасол бэлдмэлийг хэрхэн хадгалах вэ?**

25°C-аас доош хэмд хадгална. Гэрэл болон чийгнээс хамгаалахын тулд үйлдвэрийн савлагаанд нь хадгална.

Хүүхэд үзэж хүрэхээргүй газар хадгална.

Хэрэв савлалт нь гэмтсэн байвал бэлдмэлийг хэрэглэхгүй.

Савлалтан дээрх хүчинтэй хугацаа дууссанаас хойш бэлдмэлийг хэрэглэхгүй. Хүчинтэй хугацаа нь тухайн сарын сүүлийн өдөр дуусна.

**6. Савлалт ба бусад мэдээлэл**

**Найрлага:**

Үйлчлэгч бодис: уусдаг фурагин

Ут бүрд 87,4мг фурагинтай тэнцэх 100мг уусдаг фурагин агуулагдана.

Бусад туслах бодис: натрийн хлорид.

**Савлалтын агууламж ба дүрслэл:**

Улбар шар-хүрэн өнгийн мөхлөг бүхий нунтгийг ламинатан уутанд савласан байна.

15 ширхэг ламинатан уут болон эм хэрэглэх зааврыг цаасан хайрцганд савлана.